



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 63

Мөрөн

**Одон медалиар шагнуулах санал
өргөн мэдүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Соёл урлагийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Цагаан-Үүр сумын уугуул Монгол Улсын гавьяат жүжигчин Дунжаагийн Нанжидыг Монгол Улсын төрийн дээд шагнал **“Ардын жүжигчин”** цолоор,

2. Эрүүл мэндийн салбарт олон жил идэвх, зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Улаан-Уул сумын сум дундын эмнэлгийн ерөнхий эмч Оросвойн Пүрэвсүрэнг Монгол Улсын төрийн дээд шагнал **“Гавьяат эмч”** цолоор,

3. Эрүүл мэндийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Мөрөн сумын 08 дугаар багийн өндөр настан Шагдарын Дунгармааг Монгол Улсын төрийн дээд шагнал **“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”** -оор,

4. Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, санхүүгийн салбарт олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Мөрөн сумын “Тана эрдэнэ” эмийн сангийн эрхлэгч Долзодмаагийн Дэлгэр, “Биогео эко” ХХК-ны байгаль орчны аудитор Дүдлийгийн Пүрэвдаш, “Модерн гэр” ХХК-ны мужаан Найдангийн Ганбаатар, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн их эмч Пүүжийн Отгонбаяр, “Цээнэ” эмнэлгийн захирал их эмч Шагдарын Энх-Амгалан, 3-р цэцэрлэгийн ахмад нягтлан Дамдингийн Нансал, 5-р цэцэрлэгийн ахмад эмч Вандансүрэнгийн Цэцэгмаа, 5-р цэцэрлэгийн ахмад багш Балдангийн Пагмадулам, Улаан-Уул сумын шишгэд голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Мотоорын Батцогт, Арбулаг сумын өндөр настан Базарваанын Баярдалай, Шинэ-Идэр сумын ахмад багш Лувсаншаравын Балжинням, Цагааннуур сумын мал

эмнэлэг үржлийн тасгийн дарга Батаажийн Баяраа нарыг Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор,

5. Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, санхүүгийн салбарт олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Цагааннуур сумын сум дундын эмнэлгийн бага эмч Нямаагийн Даваажав, 3-р багийн малчин Самбуугийн Дугарсүрэн, Засаг дарга Халзанхүүгийн Мягмаржав, Төмөрбулаг сумын сум дундын эмнэлгийн сувилагч Жамсрангийн Гүндсамбуу, Магнайбаярын Цэрэнбадам, ЗДТГ-ын төрийн сангийн төлөөлөгч Бадраагийн Уранмандал, Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн дарга Батаажийн Нансалмаа, багийн эмч Мөнхжийн Энхтуяа, Мөрөн сумын ахмадын асрамж үйлчилгээний төвийн сувилахуйн арга зүйч Пүрэвийн Уранчимэг, аймгийн нэгдсэн эмнэлгийн сувилагч Төржаргалын Нямсүрэн, Жалбын Энхтуяа, зоонозын өвчин судлалын төвийн халдвар судлаач эмч Дэмчигийн Эрдэнэчимэг, нэгдсэн эмнэлгийн их эмч Даваадоржын Мөнхзул, аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн зохицуулагч Чойжилжавын Эрдэнэчимэг, 3-р багийн өндөр настан Бурамшингийн Баасанжав, 1-р багийн өндөр настан Должингийн Ламид, 5-р цэцэрлэгийн ахмад багш Шагдаржавын Оюун, 12-р багийн өндөр настан Лувсанренчингийн Лхагвасүрэн, Улаан-Уул сумын сум дундын эмнэлгийн бага эмч Санжгончигийн Отгон, Аюурсэд Батсуурь, Гүрбазарын Эрдэнэжаргал, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын татварын улсын байцаагч Дашжамцын Энхцэцэг, Алаг-Эрдэнэ сумын 3-р багийн малчин Пүрэвдаваагийн Амгалан, Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны үйлчлэгч Зундуйн Пунсал, бичиг хэргийн эрхлэгч Эрхэмбаярын Цэнгэлчулуун, авилга хүнд суртлын эсрэг сүлжээний зохицуулагч Даваажавын Лхагвацогт, Захирагчийн ажлын албаны нийгмийн даатгалын байцаагч Чулуунбатын Энхтайван нарыг Монгол Улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар,

6. Шагналд нэр дэвшигчдийн тодорхойлолт, холбогдох материалыг бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг /аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/ С.Цогтоод үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР